



**БОЛОВСРОЛ,  
СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН,  
СПОРТЫН ЯАМ**



**From  
the People of Japan**



**“ИНЖЕНЕР, ТЕХНОЛОГИЙН  
ДЭЭД БОЛОВСРОЛ” ТӨСӨЛ**



# ТАНИЛЦУУЛГА

## ТӨСЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БҮРЭЛДЭХҮҮН, ХАМРАХ ХҮРЭЭ

Монгол-Япон 2 орны стратегийн түншлэлийн дунд хугацааны хөтөлбөрийн хүрээнд Иенийн хөнгөлөлттэй зээлээр “Инженер, технологийн дээд боловсрол” төслийг 2014 оноос эхлэн хэрэгжүүлж байна.

### Төслийн хэрэгжих хугацаа

Энэхүү төсөл нь 2014 оны 3 сараас 2023 оны 3 сар хүртэлх нийт 9 жилийн хугацаанд хэрэгжинэ.

Зээлийн нийт хэмжээ – 7,5 тэрбум иен

Зээлийн хүү – 0.2%

Эргэн төлөгдөх хугацаа – 20 жил

Үндсэн зээлээс чөлөөлөх хугацаа – 6 жил

### ТӨСЛИЙН ЗОРИЛГО, ХҮРЭХ ҮР ДҮН

Монгол улсад өндөр мэдлэг, ур чадвар бүхий инженер, технологийн мэргэжилтэн бэлтгэх, инженерийн боловсролын өрсөлдөх чадварыг дээшлүүлэх, багшлах боловсон хүчний нөөцийг бэхжүүлэх, сургалтын орчныг шинэчлэх, чанарыг сайжруулахад оршино.

ЗОРИЛГО	ЗОРИЛТ	ХҮРЭХ ҮР ДҮН
Монгол Улсад өндөр мэдлэг, ур чадвар бүхий инженер, технологийн мэргэжилтэн бэлтгэх, инженерийн боловсролын өрсөлдөх чадварыг дээшлүүлэх, багшлах боловсон хүчний нөөцийг бэхжүүлэх, сургалтын орчныг шинэчлэх, чанарыг сайжруулах.	<ul style="list-style-type: none"> <li>- Бакалаврын хөтөлбөрийн чанарыг сайжруулах</li> <li>- Багшийн сургалт судалгааны ажлын агуулгыг бэхжүүлэх</li> <li>- Аж үйлдвэрийн салбарын чадварлаг мэргэжилтнийг бэлтгэх</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>- Өндөр мэдлэг, практик чадвар бүхий инженер, мэргэжилтнүүд бэлтгэгдэн гарна.</li> <li>- МУИС, ШУТИС-ийн инженер бэлтгэх сургалтын хөтөлбөр олон улсын жишигт хүрч.</li> <li>- Багш нарын мэргэжил арга зүй сайжирч, сургалтын чанар дээшлэн сургалтын материаллаг бааз бүрдэнэ.</li> <li>- Судалгааны ажлын чанар болон судалгааны лаборатори, тоног төхөөрөмжийн хүчин чадал сайжирч, олон улсын хамтарсан судалгаа хийгдэн бодит үр дүнг практикт нэвтрүүлнэ.</li> </ul>

Төслийн хүрээнд хэрэгжүүлэх сургалтын хөтөлбөрүүдийн үйл ажиллагааг дараах 3 бүрэлдэхүүн хэсэгт хуваан ойлгоно. Үүнд,

#### (1) Коосэн сургалтын хөтөлбөр



Дотоодын аж үйлдвэрийн бүхий л салбарын боловсон хүчний эрэлтийг богино хугацаанд хангахын зэрэгцээ аж үйлдвэрийн салбарын хөгжлийн тэргүүн эгнээнд зогсох инженер, технологийн өндөр мэдлэг, практик туршлагатай хүний нөөцийг бэлтгэхэд оршино.

#### (2) Хамтарсан бакалаврын сургалтын хөтөлбөр

Инженер бэлтгэдэг тэргүүлэх сургуулийн бакалаврын сургалтын хөтөлбөрийн чанарыг олон улсын түвшинд хүргэх, сургалтын орчинг сайжруулах, инженер, технологийн чиглэлээр өндөр мэдлэг ур чадвар бүхий чадварлаг мэргэжилтэн, хүний нөөцийг бэлтгэх явдал юм.

#### (3) Багшлах хүний нөөцийг бэлтгэх, сургалт, судалгааны ажлын агуулгыг сайжруулах/Хамтарсан судалгаа/



Магистрын сургалт



Докторын сургалт



Зэргийн бус сургалт /Зочин судлаач/

### ТӨСЛИЙН ЗОРИЛТОТ БҮЛЭГ

Төслийн хэрэгжих хугацаанд МУИС, ШУТИС-ийн багш судлаач, оюутан нийт 1000 гаруй хүнийг Японы их, дээд сургууль болон Коосэн сургуульд суралцуулахаар төлөвлөсөн. Мөн Япон Улсаас зочин багш, судлаачдыг урт болон богино хугацаагаар Монголд урин ирүүлж, хамтарсан сургалт, судалгаанд оролцуулах юм.

- Коосэн сургалтын хөтөлбөр: 200 хүн
- Хамтарсан бакалаврын сургалтын хөтөлбөр: 320 хүн
- Магистрын сургалтын хөтөлбөр: 100 хүн
- Докторын сургалтын хөтөлбөр: 60 хүн
- Зэргийн бус сургалтын хөтөлбөр: 320 удаа

## КООСЭН СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨР

Коосэн гэдэг нь Koutou Senmon Gakkou буюу өндөр түвшний мэргэжлийн сургууль гэх үгний товчлол юм. Дунд сургууль төгссөн сурагч элсэн 5 жилийн инженерийн үндсэн боловсролзэмшсэн, дээд төвшний дадлагажсан бүтээлч инженерүүд бэлтгэдэг сургууль юм. Япон улсад нийт 51 Коосэн сургууль сургалтын үйл ажиллагаа явуулдаг бөгөөд нийтгөгсөгчдийн 60% нь ажлын талбарт гарч үлдсэн хэсэг нь ахисан түвшний сургалтад үргэлжлүүлэн суралцдаг байна. Төгсөгчид нь 100% ажлын байраар хангагддаг нь бусад сургалтын байгууллагуудаас давуу талтай юм.

Дэлхийн II дайны дараа Япон улс эдийн засгаа сэргээхийн тулд аж үйлдвэрийн салбар бүрийг хөгжүүлэх бодлого хэрэгжүүлсэн. Энэ хэрэгцээ шаардлагын үүднээс аж үйлдвэрийн салбарын хүний нөөцийг богино хугацаанд бэлтгэх зорилгоор Коосэн сургуулийг байгуулсан.

Монгол улсын хэмжээнд 3 Коосэн технологийн сургууль, 1 Коосэн бэлтгэл хөтөлбөрийн төсөл үйл ажиллагаа явуулж байна.



Коосэн сургалтын онцлог

- 1) 5 жилийн сургалттай бөгөөд дэд бакалаврын зэрэг олгоно.
- 2) Мэргэжлийн хичээлүүд түлхүү орно. /1 дүгээр курсээс эхлэн мэргэжлийн хичээлүүд орно. Туршилт, бие даалтын цаг ихтэй/
- 3) Чөлөөт цагаараа дугуйлан, клубт хамрагдах боломж өргөн.
- 4) Үргэлжлүүлэн суралцах, мөн ажилд орох сонголтоос сонгох боломжтой.
- 5) Ажилд орох боломж 100%. Коосэн сургууль төгсөгчдийн хувьд 1 хүнд 20 ажлын байрны санал ирдэг.
- 6) Хичээлийн байр, орчин /Оюутны суралцах таатай орчин бүрдүүлсэн Коосэний хотхоныг бүрдүүлсэн бөгөөд орчин үеийн судалгааны лаборатори болон компьютерээр тоноглогдсон. Коосэн сургууль бүр дотуур байртай/

## БЭЛТГЭЛ КООСЭН ХӨТӨЛБӨР

Аж үйлдвэрийн салбарын хүний нөөцийн эрэлтийг богино хугацаанд хангах, аж үйлдвэрийн салбарын хөгжлийн тэргүүн эгнээнд зогсох инженер, технологийн өндөр мэдлэг, практик дадлага туршлагатай хүний нөөцийг бэлтгэх зорилгоор Япон улсын Коосэн сургуулиудтай хамтран Коосэн хөтөлбөрийг хэрэгжүүлж байгаа билээ. Оюутнуудыг Япон Улсын Коосэн сургуулийн 3 дугаар курсээс шилжүүлэн суралцуулахын тулд Монгол улсын шинжлэх ухаан, технологийн их сургууль дээр 1.5 жилийн бэлтгэл сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлж байна.

**Үр дүн 1:** Монгол улсын аж үйлдвэрийн салбарын хөгжлийн тэргүүн эгнээнд зогсох инженер, технологийн өндөр мэдлэг, практик туршлагатай хүний нөөцийг бэлтгэнэ.

**Үр дүн 2:** Монгол улсын эдийн засгийн хөгжлийн төлөвлөгөөнд үндэслэн аж үйлдвэрийн салбарт тулгамдаж буй инженерийн хүний нөөцийн дутагдлыг богино хугацаанд бэлтгэх ажилд үнэтэй хувь нэмэр оруулна.

Бэлтгэл сургалтын хөтөлбөрт эхний 1 улирал дээд боловсролын суурь хичээл болон Япон хэлний хичээл орно. Хөтөлбөрийн төгсгөл үе буюу 2 улирал хичээллэсний дараа оюутнууд дараах мэргэжлүүдээс сонгох бөгөөд тухайн мэргэжлийн дагуу Япон улсын Коосэн сургуульд суралцана.

Японы Коосэн сургуульд:

- Механик инженер
- Цахилгаан, электроник
- Мэдээллийн систем
- Хүрээлэн буй орчны инженерчлэл
- Барилга, архитектур
- Материал судлал зэрэг мэргэжлээр инженерийн боловсрол олгоно.



Оюутан Монголд 1.5 жил суралцах хугацааны сургалтын төлбөр болон бусад холбогдох зардлыг 100% өөрөө хариуцах бөгөөд Японы их дээд сургуульд элсэн суралцах шалгалтанд тэнцэж, Англи хэлний TOEIC шалгалтын босго онооны болзол хангасан тохиолдолд Японы Коосэн сургуулийн 3 дугаар курсээс шилжин суралцах эрхтэй болно. Энэ тохиолдолд Япон Улсад суралцах хугацааны сургалтын төлбөр, элсэлтийн төлбөр, амжиргааны зардлыг төслийн санхүүжилтээр өөрөөр хэлбэл зээл хэлбэрээр хийгдэнэ.

Оюутан Японы Коосэн сургуульд 3 жил амжилттай суралцан төгсөж ирээд Монголд тогтвор суурьшилтай 5 жил ажилласан тохиолдолд суралцах хугацаанд авсан зээл нь тэтгэлэг болж чөлөөлөгдөнө.

Монголд суралцсан 1.5 жил, Японд суралцсан 3 жилийн турш судалсан нийт кредитийг цуглуулан тухайн мэргэжлээр бакалаврын зэрэг авах кредитийн зөрүүг ажиллах хугацаандаа нөхөн судалж бакалаврын зэрэг авах боломжтой.

## Элсэгчдэд тавигдах шаардлага

Бэлтгэл хөтөлбөр		Япон улсад шилжин суралцахад	
1	Монгол улсын иргэн /21 нас хүртэлх/	1	Бэлтгэл сургалтын хөтөлбөрийн төгсгөлд Японы их дээд сургуульд элсэн суралцах шалгалтыг /EJU/ өгч тэнцсэн байх.
2	Урьдчилсан шалгалтад 50-аас дээш оноо авсан байх	2	Англи хэлний TOEIC – шалгалтын 400-с оноо авсан
3	ЭЕШ босго оноо математик 650, физик 650	3	Суралцсан хугацааны оюутны голч дүн 2.5 –аас дээш
4	Инженер, технологийн чиглэлээр суралцаж буй бол голч дүн 3.0 байх	4	Эрүүл мэндийн шаардлага хангасан байх



# ХАМТАРСАН БАКАЛАВРЫН СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨР

Монгол улсын инженер, технологийн дээд боловсролын чанарыг сайжруулан өрсөлдөх чадварыг бэхжүүлэх ажлын хүрээнд БСШУСЯ-наас ШУТИС болон Японы их, дээд сургуулийн консорциумын гишүүн сургуулиудтай хамтран “Хамтарсан бакалаврын сургалтын хөтөлбөр”-ийг хэрэгжүүлж байна.

Суралцагчдад тавих шаардлагыг бүрэн хангаж, сонгон шалгаруулалтад тэнцсэн оюутан Хамтарсан бакалаврын сургалтын хөтөлбөрт элсэн суралцана. ШУТИС-ийн Барилга, архитектурын сургууль болон Механик тээврийн сургууль дээр хэрэгжих 2.5 жилийн сургалтын хөтөлбөрт хамрагдан амжилттай суралцсан оюутан кредит дүйцүүлэн Японы инженер, технологийн их дээд сургуулийн 3-р курст шилжин суралцах бөгөөд Япон улсад 2 жил суралцан хоёр улсын их сургуулийн бакалаврын зэргийн дипломтой төгсөнө.

Монголд суралцах 2.5 жилийн хугацааны сургалтын төлбөрийг оюутан өөрөө хариуцах бөгөөд Японд суралцах хугацааны сургалтын төлбөр, амжиргааны зардал, Японд зорчих онгоцны тийзийн зардал зэргийг боловсролын зээлийн сангаас зээл хэлбэрээр олгоно. Оюутнууд төгсөж ирээд өөрийн эзэмшсэн мэргэжлээрээ 5-аас доошгүй жил эх орондоо үр бүтээлтэй ажилласан тохиолдолд уг зээл нь тэтгэлэг болно.

### Хөтөлбөрийн зорилго

- Бакалаврын сургалтын хөтөлбөрийг сайжруулах
- Сургалтын орчинг дээшлүүлэх, лабораториудыг шинэчлэх
- Японы их, дээд сургуульд оюутан шилжүүлэн суралцуулах

### Хөтөлбөрийн агуулга

Хамтарсан бакалаврын сургалтын хөтөлбөр нь ШУТИС болон ЯИДСК-тай хамтарч дүйцүүлсэн хичээлийн хөтөлбөрөөр барилга, архитектурын сургууль болон механик тээврийн сургууль дээр хэрэгжих бөгөөд сургалтын төлөвлөгөөний дагуу ерөнхий эрдмийн хичээл, мэргэжлийн хичээлийн суурь хичээлийг судлахын хажуугаар төслөөс санхүүжүүлэх Япон хэлний хичээлийг судална.


### Суралцах чиглэл:

- Барилга, хүрээлэн буй орчны инженер
- Архитектур
- Механикийн инженер мэргэжлээр суралцана.

### Сургалтын хуваарь, хугацаа

Он	2014	2015	2016	2017	2018	2019	2020	2021	2022	2023
Элсэлт 1			Курс 1	Курс 2	Курс 3	Курс 3	Курс 4			
Элсэлт 2				Курс 1	Курс 2	Курс 3	Курс 3	Курс 4		
Элсэлт 3					Курс 1	Курс 2	Курс 3	Курс 3	Курс 4	
Элсэлт 4						Курс 1	Курс 2	Курс 3	Курс 3	Курс 4

 Монголд суралцах  
/Сургалтын төлбөрөө өөрөө хариуцах/

 Японд суралцах  
/Боловсролын зээлд хамрагдах/

**Хамрах хүрээ:** Тухайн хичээлийн жилд ШУТИС-ийн барилга, архитектурын сургууль болон механик, тээврийн сургуульд элсэн суралцах оюутан байна.

### ТАВИГДАХ ШААРДЛАГА:

- Монгол улсын иргэн байх
- Бүрэн дунд боловсрол эзэмшсэн
- 20 нас хүртэлх
- Урьдчилсан шалгалтад 50-аас дээш оноо авсан байх
- ЭЕШ-ийн босго оноо:
  - Математик 680
  - Физик 680
  - Хар зураг 650
- Боловсролын зээлийн шаардлага хангасан байх

### Япон хэлний сургалт:

Хамтарсан бакалаврын сургалтын хөтөлбөрийн нэг онцлог нь оюутан 2,5 жил суралцах хугацаандаа Япон хэлийг хэрэглэж чаддаг болох түвшинд хүрэх явдал юм. Япон хэлний хичээлийг өдөрт 2 цагаар долоо хоногт 10 цаг судлах ба Японы их, дээд сургуулийн консорциумаас профессор багш нар ирж мэргэжлийн хичээлийг Япон хэл дээр заана.

### Японы их, дээд сургуулийн консорциум

“Инженер, технологийн дээд боловсрол” төслийн хүрээнд хамтарсан бакалаврын сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэхээр Япон улсын инженер бэлтгэдэг их, дээд сургуулиудын консорциумыг байгуулан Монгол улсын тэргүүлэх их сургуулийн нэг ШУТИС - тай хамтын ажиллагааны гэрээг байгуулан ажиллаж байна. Хамтын ажиллагааны хүрээнд инженерийн дээд боловсролын сургалтын хөтөлбөр боловсруулах, багшлах хүний нөөцийн чадавхийг дэмжих, суралцагчийн мэдлэгийг бодитойгоор үнэлэх, сургалтын заах арга зүйг сайжруулан Японы их, дээд сургуулийн инженерийн хөтөлбөртэй дүйцэхүйц хэмжээнд хүрч цаашлаад олон улсад хүлээн зөвшөөрөгдөх инженерийг эх орондоо бэлтгэх явдал юм.



Нагаокагийн технологийн их сургууль



Кюүшүгийн их сургууль



Киотогийн технологийн дээд сургууль



Тоёохашигийн технологийн их сургууль



Нагоягийн технологийн дээд сургууль



Кюүшюүгийн технологийн дээд сургууль



Китамигийн технологийн дээд сургууль



Вакаямагийн их сургууль



Ямагучигийн их сургууль



Кумамотогийн их сургууль

### СОНГОН ШАЛГАРУУЛАЛТ:

- Урьдчилсан шалгалт /жил бүрийн 4-5 сард/
- Бичиг баримтын бүрдэл
- ЭЕШ-ийн босго оноогоор жагсаах



## ХАМТАРСАН СУДАЛГАА

Хамтарсан судалгааны хөтөлбөрийн гол зорилго нь Монгол улсын тэргүүлэх хоёр их сургуулийн (МУИС, ШУТИС) инженер, технологи, байгалийн ухааны чиглэлийн багш, судлаачдад дэмжлэг үзүүлж, Японы их, дээд сургуулиудтай хамтран хамтарсан судалгааг хэрэгжүүлж, их сургуулиудын сургалт, судалгааны ажлын чанар, чадавхийг дээшлүүлж, хүний нөөцийг сайжруулж, үйл ажиллагааг бэхжүүлэхэд оршино.

Сургалт, судалгааны ажлын чанар, үр дүнг дээшлүүлэх үүднээс хоёр орны их сургуулиудын хамтын ажиллагаанд суурилан Монгол улсын их сургууль болон Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн тэргүүлэх 8 чиглэлийн хүрээнд хамтарсан судалгааны 20 төслийг 2015 оноос хэрэгжүүлж байна. Эдгээр төслүүд амжилттай хэрэгжсэнээр олон улсад эрдэм шинжилгээний бүтээл хэвлүүлэх, шинэ бүтээгдэхүүн гаргах, их сургуулиудын дэргэд гарааны компани бий болох юм.

Хөтөлбөрийн хүрээнд хамтарсан судалгааны багийн гишүүдийг Японы их, дээд сургуульд суралцуулах, туршлага солилцох, дадлагажуулах замаар мэдлэг чадварыг нь дээшлүүлэхийн зэрэгцээ Монгол дахь их сургуулиудын судалгааны орчин, нөхцлийг сайжруулах, лабораторийн тоног төхөөрөмжийг хамтарсан судалгааны үйл ажиллагаатай уялдуулан шинэчилнэ.

Хамтарсан судалгааг үр дүнтэйгээр хэрэгжүүлэх үүднээс Японы их, дээд сургуулиудаас багш, профессоруудыг зочин багш, судлаачаар хамтарсан судалгааны хүрээнд Монгол улсад урьж ажиллуулж байна.

**Үр дүн 1:** МУИС болон ШУТИС-ийн сургалт, судалгааны ажлын чанар, чадавхийг бэхжүүлнэ.

**Үр дүн 2:** Хамтарсан судалгаагаар дамжуулан Япон, Монголын их, дээд сургуулиудын хамтын ажиллагааг хөгжүүлнэ.

**Үр дүн 3:** МУИС болон ШУТИС-д шинэ лаборатори байгуулж, сургалт, судалгааны тоног төхөөрөмж шинэчлэгдэнэ.

### I. Багшлах хүний нөөц, сургалт, судалгааны агуулгыг бэхжүүлэх

/Магистр, доктор, зэргийн бус сургалт/

- МУИС болон ШУТИС-ийн багш, судлаач 160 хүнийг Японы их, дээд сургуулиудад Магистр, докторын сургалтын хөтөлбөрт хамруулах
- Японы их, дээд сургуулиуд дээр Зэргийн бус сургалтын хөтөлбөрөөр 320 хүнийг мэргэжил дээшлүүлэх, судалгаа, туршилт хийлгэх

### II. Судалгааны тоног төхөөрөмж нийлүүлэх:

Судалгааны нээлттэй лаборатори байгуулах, тоног төхөөрөмж нийлүүлэх

### III. Судалгааг дэмжих санхүүжилт олгох:

Судалгааны материал, хэрэглэгдэхүүн болон ном, сурах бичиг худалдаж авах гэх мэт.



## "ИНЖЕНЕР, ТЕХНОЛОГИЙН ДЭЭД БОЛОВСРОЛ" ТӨСЛИЙН САНХҮҮЖИЛТЭЭР МУИС ДЭЭР ХЭРЭГЖИЖ БҮЙ ХАМТАРСАН СУДАЛГАА

Сургуулийн тэргүүлэх чиглэл	№	Судалгааны сэдэв	Монгол талын багийн ахлагч	Япон талын их сургуулиуд
1 Дэвшилтэд материалын судалгаа	1	Монгол орны эрдэс материалд тулгуурласан хүрээлэн буй орчны инженерчлэл, цемент бэхжүүлэгч, хөвүүлэн баяжуулагчийн судалгаа	О.Алтансүх	Миязакагийн их сургууль Каназавагийн их сургууль Кюүшүгийн их сургууль
	2	Наноматериал ба хэрэглээ	Н. Жавхлантөгс	Ёкохамагийн үндэсний их сургууль
2 Биологийн нөөцийг тогтвортой ашиглах	3	Монголын ургамлаас биологийн идэвхит нэгдлийг илрүүлэх, хэрэглээнд нэвтрүүлэх	Ж.Батхүү	Тохогийн их сургууль Тохоку эм зүйн их сургууль Нагоягийн их сургууль Сумитомо химийн компани
	4	Монгол орны биологийн нөөцийг инженерчлэлийн зорилгоор хэрэглэх нь: Хүрээлэн буй орчны биоинженерчлэл ба биотехнологи	Р.Чинзориг	Эхимэгийн Их Сургууль, Рикен судалгааны төв, Тохогийн Их Сургууль
3 Сэргээгдэх эрчим хүчийг ашиглах, цэвэр эрчим хүчний судалгаа	5	Сэргээгдэх эрчим хүч, нарны эрчим хүчийг инженерчлэх	А.Амарбаяр	Токиогийн ХАА ба Технологийн их сургууль Токиогийн Технологийн их сургууль AIST-RCPV Нарны зайн судалгааны төв
	6	Монгол орны залуу хүрэн нүүрсийг ашиглах цэвэр ба үр ашигтай технологийг бий болгох нь	Б.Энхсаруул	Кюүшүгийн их сургууль
4 Микроэлектроник ба тооцоолон бодох шинжлэх ухаан	7	Утасгүй холбоо болон кодлолд зориулсан хагас дамжуулагч чипүүд	М.Баярпүрэв	Токиогийн их сургууль Нагоягийн их сургууль
	8	Цогц процессын загварчлал, оновчлол ба симуляци	А.Энхбаяр	Киотогийн их сургууль, Нанзаны их сургууль Кумамотогийн их сургууль, Иватэгийн их сургууль Нагоягийн их сургууль
	9	Чадлын электроник ба үйлдвэрийн автоматжуулалтын судалгаа хөгжүүлэлт	Д.Баясгалан	Кумамотогийн их сургууль, Нагоягийн их сургууль
	10	Сансрын инженерчлэлийн програм	Р.Цолмон	Кюүшүгийн технологийн дээд сургууль Хоккайдогойн их сургууль Чибагийн их сургууль



## "ИНЖЕНЕР, ТЕХНОЛОГИЙН ДЭЭД БОЛОВСРОЛ" ТӨСЛИЙН САНХҮҮЖИЛТЭЭР ШУТИС ДЭЭР ХЭРЭГЖИЖ БҮЙ ХАМТАРСАН СУДАЛГАА

Сургуулийн тэргүүлэх чиглэл	№	Судалгааны сэдэв	Монгол талын багийн ахлагч	Япон талын их сургуулиуд
1 Шинэ материал, нөөцийн технологийн инженерчлэл	1	Монгол орны эрдэс баялгийн суурь судалгаа	С.Жаргалан	Кюүшюгийн их сургууль Акитагийн их сургууль Тохокугийн их сургууль
	2	Үнсийг барилгын материалын үйлдвэрлэлд ашиглах ногоон технологи	Д.Сүнжидмаа	Тохокугийн их сургууль
	3	Нунтаг металлурги метал боловсруулалтын судалгаа	М.Дэлгэрмаа	Нийгатагийн их сургууль Нийгатагийн технологийн их сургууль
2 Эрчим хүч, байгаль орчны инженерчлэл	4	Монгол дахь тэнгэрийн дэд бүтэц: Агаар сансарын механик инженерийн мэдлэг ба логистик, хүрээлэн буй орчны хяналт шинжилгээ	Б.Баасандаш	Нагаокагийн техникийн их сургууль
	5	Хүрээлэн орчны бохирдлын хяналтын цогцолбор судалгаа, тогтвортой хөгжил: Төв Монголын Туул, Хараа голын ай савуудын жишээн дээр	О.Мөнхцэцэг	Нагоягийн их сургууль
	6	Эрчим хүчний дамжуулалт, түгээлтийн инновацийн судалгаа	Б.Сэргэлэн	Токиогийн их сургууль Когакюны их сургууль Дошишагийн их сургууль Ашикагагийн технологийн их сургууль
	7	Монгол орны хүрээлэн буй орчин, газар хөдлөлтийн инженерчлэлийн судалгаа	Ц.Цоггэрэл	Тохокугийн их сургууль Чибагийн их сургууль
3 Автоматжуулалт, системийн инженерчлэл	8	Дижитал технологид суурилсан судалгаа хөгжүүлэлт	Г.Хишигжаргал	
4 Био инженеринг (хүнс, эм бэлдмэл, биопринтинг)	9	Монголын хүнсний зарим бүтээгдэхүүн хатаах аргын харьцуулсан судалгаа	Ц.Одбаяр	Обихирогийн их сургууль Цүкүбагийн их сургууль
	10	Хүний тогтвортой хөгжлийг хангах Био-инженерчлэлийн судалгаа хөгжүүлэлт	Д.Ганбат	Хоккайдогойн их сургууль Цүкүбагийн их сургууль Киотогийн технологийн их сургууль

## Магистр, доктор, зэргийн бус сургалтын хөтөлбөр



## Төслийн зөвлөх "Азиа Сийд" ашгийн бус байгууллага

**Зорилго:** МУИС болон ШУТИС-ийн инженер, технологи, байгалийн ухааны чиглэлийнхүний нөөцийг бэхжүүлэх, чадавхижуулах.

**Танилцуулга:** Япон улсын шилдэг их дээд сургуулиудад 100 магистр, 60 доктор оюутныг сургана. Суралцах хугацааны сургалтын төлбөр, замын зардал болон сар бүрийн амжиргааны зардлыг зээлээр санхүүжүүлнэ. Суралцах хүмүүс Боловсролын зээлийн сан болон захиалагч байгууллагатай (МУИС, ШУТИС) зээлийн гэрээг хийж, сургуулиа амжилттай төгсөж ирээд захиалагч байгууллагадаа 5 жил үр бүтээлтэй ажилласан тохиолдолд зээлийн гэрээ дуусгавар болж, зээл нь тэтгэлэг болно.

### Зэргийн бус сургалт /Зочин судлаач/

Хамтарсан судалгааг үр дүнтэй хэрэгжүүлэх үүднээс хамтарсан судалгааны багийн гишүүдийг Япон улсад урт, богино хугацаагаар туршилт, судалгаа хийлгэхэд чиглэгдэнэ.

**Үр дүн 1:** Магистр ба түүнээс дээш эрдмийн зэрэгтэй чадварлаг багшлах хүний нөөц бэлтгэгдэн гарна.

**Үр дүн 2:** МУИС, ШУТИС-ийн багш, судлаачдын сургалт, судалгааны ажлын чадвар дээшилнэ. Цаашилбал сургалтын чанарт эерэг өөрчлөлт гарна.

### Хамрах хүрээ:

1. Инженер, технологи, байгалийн ухааны чиглэлээр МУИС болон ШУТИС-д ажиллаж буй эрдэм шинжилгээний ажилтан, залуу багш нар;
2. МУИС болон ШУТИС-д хамтарсан судалгааны сэдвээр эрдэм шинжилгээ, судалгааны ажилд хамтран ажиллаж буй багш, судлаачид, болон эрдэм шинжилгээний ажилтан;

### Тавигдах шаардлага:

1. Монгол улсын иргэн байх;
2. Магистр -35 нас хүртэлх; Докторт- 40 нас хүртэлх
3. Монгол Улсын магадлан итгэмжлэгдсэн их, дээд сургууль болон гадаадын их, дээд сургуулийг инженер, технологи, байгалийн ухааны чиглэлээр суралцаж төгссөн байх;
4. Бакалаврын дипломын голч дүн 2.8, магистрын дипломын голч дүн 3.0- оос дээш байх;
5. Гадаад хэлний шалгалт: Япон хэлний түвшин тогтоох JLPT шалгалтын N2 түвшин, эсвэл Англи хэлний TOEFL шалгалтын оноо PBT-500, IELTS шалгалтын оноо 5.0 ба түүнээс дээш байх;
6. Японы их сургуульд элсэн суралцах болзол хангаж, суралцах урилга хүлээн авсан байх;
7. Сургууль /ажлын газар/ нь тухайн хөтөлбөрт суралцахыг дэмжсэн байх;
8. Суралцагчдад зээл олгох, эргэн төлүүлэх гэрээ болон уг гэрээний хавсралт үл хөдлөх хөрөнгийн барьцааны гэрээний нөхцлийг зөвшөөрсөн байх;

### Сонгон шалгаруулалт

1. СУРГУУЛИЙН АЖЛЫН ХЭСЭГ  
Нэр дэвшигчийг тодруулах

2. ТӨСЛИЙН НЭГЖ  
/Ажлын хэсэг/  
Бичиг баримтын бүрдүүлэлт  
болон ярилцлага

3. УДИРДАХ ХОРОО  
Хэлэлцэж баталгаажуулах

4. БСШУСЯ  
Сайдын тушаал

"Азиа Сийд" ашгийн бус байгууллага нь 1991 оноос эхлэн Ази, Африкийн улс орнуудад 20 гаруй төсөл хэрэгжүүлж байгаа Япон улсын ашгийн бус байгууллага юм. Тус байгууллага нь нийт 34 хүний бүрэлдэхүүнтэйгээр Япон, Монгол, Индонез, Малайз, Тайланд, Мьянмар, Вьетнам зэрэг орнуудад салбар оффисуудаа байгуулан үйл ажиллагаагаа явуулж байна. 2015 оноос эхлэн "Инженер, технологийн дээд боловсрол" төсөлд зөвлөх үйлчилгээ үзүүлэх, хөтөлбөр боловсруулах, дэмжих үйлчилгээ үзүүлж байна.

### "АЗИА СИЙД" АШГИЙН БУС БАЙГУУЛЛАГИЙН ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГАА

- Судалгаа: "Азиа Сийд" нь Азийн улс орнуудад боловсрол, шинжлэх ухаан, технологи, эдийн засаг, аж үйлдвэр, соёлын гэх мэт хүний нөөцтэй холбоо бүхий салбарт дүн шинжилгээ хийж асуудлыг тодорхойлох, мэдээлэл цуглуулах судалгаануудыг хийж ирсэн. Тэдгээр судалгааны үр дүнг харгалзан "Азиа Сийд" нь харилцан, хамтран ажиллах боломжтой тодорхой төслүүдийг боловсруулж, төрийн болон хувийн хэвшлийн холбогдох байгууллагад санал болгодог.
- Гадаадад суралцахад дэмжих үйлчилгээ: "Азиа Сийд" нь Азийн олон тооны их дээд сургуулийн оюутнууд болон төгсөгчдөд Японд амьдрах хугацаанд нь төрөл бүрийн дэмжлэг үзүүлдэг. Үүнд, мэдээллээр хангах, тэтгэлгээр цаашид суралцах, их дээд сургуульд элсэх, өдөр тутмын амьдралд туслах, хичээлийн үд дүнгийн үнэлгээ, амралтын үеэр хийх дадлагын хөтөлбөр, төгсөгчдийн үйл ажиллагаа гэх мэт Азийн улс орнуудын оюутнуудыг Япон улсад үр дүнтэй, сэтгэл хангалуун байхад чиглэгдсэн үйл ажиллагаанууд багтдаг.
- Хамтарсан хөтөлбөр: "Азиа Сийд" нь Японы их дээд сургуулиудад хамруулахын өмнө тухайн улсад боловсрол олгох хөтөлбөрийг хэрэгжүүлдэг ба үүнд япон хэлний хичээл багтдаг. Мөн Японы боловсролын системийн боломжийг ашиглан Японы их дээд сургуулиудын 2 ба 3-р курст шилжин суралцаж, бакалаврын зэрэг хүртэх хамтарсан хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж байна.
- Азийн улс орнуудын хувьд их дээд сургуулиудыг сайжруулах хөтөлбөр: "Азиа Сийд" Азийн орнуудын дээд боловсролын байгууллага, ихэвчлэн их, дээд сургуулиудын шинэчлэлийн төслүүдийг дэмждэг. Хамтарсан судалгаа, багш, судлаачдын солилцоо, хүний нөөцийн хөгжил, сургалтын хөтөлбөрийг сайжруулах, байгууллагын хөгжил, сургалтын шаардлагатай материал, тоног төхөөрөмжийн худалдан авалт зэргийг багтаасан Азийн их дээд сургуулиуд, тэдний лаборатори, Японы түншүүдтэйгээ харилцан сайн санааны хамтын ажиллагааг хөгжүүлэхэд чиглэсэн тодорхой арга хэмжээнүүдийг хэрэгжүүлдэг.



"Инженер, технологийн дээд боловсрол" төсөл  
Утас: 315563  
И-мэйл: [piu.heedproject@gmail.com](mailto:piu.heedproject@gmail.com)  
Хаяг: ШУТИС-ийн Төв номын сан 605 тоот,  
Сүхбаатар дүүрэг, 8-р хороо  
Улаанбаатар, Монгол улс